



**НИЙСЛЭЛИЙН
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 4/54

Улаанбаатар хот

**Тооллогын ажлын хэсэг байгуулах
тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2, 70.2.1, 70.2.2, 71 дүгээр зүйлийн 71.1, 72 дугаар зүйлийн 72.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 12.2.1, 12.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. 2021 оны жилийн эцсийн тайлан гаргахтай холбогдуулан байгууллагын эд хөрөнгөд 2021 оны жилийн эцсийн тооллого явуулах ажлын хэсгийг хавсралт ёсоор баталсугай.

2. Тооллогын бэлтгэл ажлыг ханган хуваарь гарган батлуулж, хуваарийн дагуу 2021 оны 12 дугаар сарын 13-наас 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрүүдэд зохион байгуулж, тооллогын дүнг 2021 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн дотор газрын даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Галмандах), Ерөнхий нягтлан бодогч (Х.Цогзолмаа) нарт тус тус даалгасугай.

3. Эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах, агуулахын эмх цэгц, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, анхан шатны бүртгэл хөтлөлт, урьдах тооллогоор өгсөн үүргийн биелэлт зэргийг тооллогын явцад шалгаж, дутагдлыг арилгах арга хэмжээ авч ажиллахыг ажлын хэсгийн гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Х.ЭРДЭНЭБИЛЭГ